


# ШУУТЫН ЦАГААГЧ ГҮҮ

Монгол ардын үлгэр





# Цуутын цагаагч гүү



Улаанбаатар хот  
2007 он





**Ц**уутын цагаагч гүү цолмон цоохор унагатай, далан хоёр ижилтэй, дархан хул азаргатай юм санжээ. Тэр нутагт нэгэн зун ган болж, газарт ногоо гарсангүй гэнэ.



Тэгэхэд нь цуутын цагагч гүү далан хоёр ижил, дархан хул азаргандаа хэлээд, нутгаасаа гарч гурван жилийн газар ногоо хөөж явж гэнэ. Гэтэл ногоо их гарсан нэгэн сайхан нутаг дайралдаж гэнэ. Тэнд нутаглаж, усны сайныг ууж, өвсний сайныг идэж, хужрын сайныг долоож байж гэнэ.









Нэгэн өдөр цуутын цагаагч гүү далан хоёр ижил, дархан хул азаргатайгаа голын хөвөөн дээр тоглож байж гэнэ. Тэгсэн чинь тэр голын хөвөөн дээр галууны долоон өндгийг хага гишгэж орхижээ.

Тэр даруй цуутын цагаагч гүү далан хоёр ижил, дархан хул азаргандаа,

- Одоо явцгаая. Одоо бид ингэж хүний нутагт явж байгаад шувууны долоон цагаан өндгийг алж, дайсан болоод, энд нутаглаж яаж болох вэ? Одоо орон нутагтаа буцъя. Шувууны цэрэг ирж, биднийг өглөөний нарнаар дайсагнан алах гэж байна гэжээ.

Тэгтэл, далан хоёр ижил нь үгэнд нь орсонгүй гэнэ. Маргааш өглөө нь үнэхээр шувууны сүрэг буцлан ирж, далан хоёр ижил, дархан хул азаргатай нь (нум сумаар харваж) тоншиж алаад дуусч гэнэ. Ганцхан цуутын цагаагч гүү л унагатайгаа хоцорч гэнэ.



Тэгтэл энэ хоёрыг алах гээд шувууны цэрэг бүслээд байж гэнэ. Тэгтэл сум нь цөөрөөд нэг талаас нь довтолдог болжээ. Цуутын цагаагч гүүг хойд талаас нь харван довтолоход унагаа урдаа авч, хамгаалав гэнэ. Өмнө талаас нь довтолон харвахад унагаа газрын дээд талдаа авч хамгаалав гэнэ. Дээд талаас нь дайрахад унагаа доод талдаа авч хамгаалав гэнэ. Тэгсээр байтал шувууны цэрэг сумаа дуусаад, алах горьдол тасран цөхрөөд буцжээ.

Цуутын цагаагч гүү ингэж амьд мэнд гараад:

За үр минь, одоо орон нутагтаа буцъя гээд гурван жилийн цаана байгаа нутагтаа жилийн газрыг сараар, сарын газрыг өдрөөр товчлоод буцаж гэнэ.







Буцаж явтал унага нь ээжээсээ,

- Ээж ээ таны биед энэ сарайсан сэрийсэн чинь юу вэ? гэж гэнэ. Эх нь,

- Аа хүү минь, Харганатын даваагаар давахад харгана бударгана наалдаа биз дээ" гэж гэнэ. Унага бас асуув,

- Ээж ээ ээж ээ! Таны биеэс огил сэгэл улаан юм гараад байна. Тэр чинь юу вэ? гэж. Эх нь,

- Хүү минь, Зостын даваагаар давахад зос наалдаа биз дээ гэж.


Унага бас асуудаг байж,

- Ээж ээ ээж ээ, дөмөр дөмөр алхдаг дөрвөн хөл чинь юунд солбиж гуйваад байна? гэжээ. Эх нь,

- Ээ хүү минь, газрын хол, усны уртаас яваад ядраа биз дээ гэж хариулж гэнэ.

Ингэж явсаар байгаад хоёулаа нутагтаа ороод иржээ. Цуутын цагаагч гүү унагаа нутагтаа хүргэж ирээд, шархны халуунаас болж нас нөгчих болжээ. Нас нөгчихдөө унагандаа гэрээс үгээ захисан нь:

- Хүү минь, ар газар битгий унтаж яваарай, шуурга их, чоно ирээд байдаг юм шүү. Өвөр газар унтаж яваарай, нөмөртэй байдаг юм шүү. Айлын үүдээр битгий гарч яваарай, хүүхэд нохой нь явуулдаггүй юм шүү. Араар нь гарч яваарай. Амьтанд үзэгдэхгүй гардаг юм шүү. Айлын бууцан дээр битгий унтаж яваарай, зүү тэвнэ шорлоод байдаг юм шүү. Эрүүл газар унтаж яваарай. Ижилтэйгээ явахдаа адууны захад гарч яваарай. Усанд орж уухдаа түрүүнд нь ууж яваарай.




Адууны сүүлд  
орвол адууны  
эзэн зодож цохиод  
болдоггүй юм шүү.  
Дунд нь битгий орж  
яваарай. Дайрч  
өшиглөж алчих гээд  
байдаг юм шүү. За  
хүү минь ээжийнхээ  
шарил дээр гурван жил  
болоод ирээрэй” гэжээ.

Цолмон цоохор  
унага ээжийнхээ үгэнд  
оролгүй ар газар  
унтвал, чоно түүнийг  
барьж идэх гээд, салхи  
шуурга хөлдөөчих  
гээд байж гэнэ. Иймд  
бөн бөн уйлаад бөжир  
бөжир жороолоод  
“Ээжийн минь хэлсэн  
яасан сайхан үнэн үг  
вэ? гэж өвөр газар  
унтдаг болов. Тэгтэл  
нам сайхан унтав гэнэ.









Тэгээд бас ээжийнхээ үгэнд оролгүй, айлын үүдээр гарч гэнэ. Ноход нь барьж идчих гээд, хүүхэд барьж унах гээд зүдэрч гарав гэнэ. Тэгэхэд “Ээжийн минь хэлсэн, яасан үнэн үг вэ?” гэж бөн бөн уйлаад бөжир бөжир жороолоод айлын араар гараад явсан чинь нам сайхан гараад явж гэнэ.

Ижлийнхээ өмнө яваад усанд орж гэнэ. Тунгалаг сайхан ус олж, ууж гэнэ. Олон ижлийнхээ сүүлд ороод явсан чинь адууны эзэн зодож нүдээд, усны булингартайг ууж гэнэ. Адууны дунд явсан чинь ижилүүд нь өшиглөж алчих гээд явуулсан гэнэ.





Адууныхаа захад гараад явсан чинь амьтан хүн зодохгүй, ижил нь тонгорохгүй, өвсний соргогийг идэж аятай сайхан явдаг болов. Ингээд, "Миний ээжийн хэлсэн, яасан сайхан үнэн үг вэ?" гэж толгойгоороо тоглож, тоосноосоо бусгасаар явжээ.

Гурван жил бололгүй эхийн шарил дээр очсон чинь, сэвс гүзээ (яс үс) хоёр нь байжээ. Гурван жил болоод ээж дээрээ бас эргэж очсон чинь, бал бурам хоёр ургачихсан байж гэнэ.

Түүнийг нь идээд толгойгоороо тоглоод тоосноосоо бусгаад явж байтал эрийн сайн Эрхийн мэргэн хүү (Эрийн хувилбарт эрийн сайн Хан Харанхуй гэнэ) гэдэгтэй уулзав гэнэ. Тэр хүү унаганаас:

- Чи миний морь мөн үү гэжээ.

- Мөн гэжээ.

- Миний эзэн мөн бол намайг барьж ав гэж унага хэлжээ.

Тэр хүү түүнийг мөнгөн хазаараар хазаарлаж, мөнгөн эмээлээр эмээллэв гэнэ. Унага:

- За, чамайг миний эзэн мөн биш хоёрыг ялгаж мэдэхийн тулд уулыг тал болтол, талыг там болтол бухъя. Хэрэв чи тогтвол миний эзэн мөн бөгөөд сайн эр гэж мэдь. Тогтохгүй ойчвол чи миний эзэн биш, би ч чиний морь биш гээд уулыг тал болтол, талыг там болтол бухсанд, Эрхий мэргэн хүү тогтохоороо тогтов.

Ингээд үнэхээр эзэн нь морио мэдэж морь нь эзнээ танив гэнэ. Тэгээд эзэн морь хоёулаа амар сайхан жаргаж гэнэ.

## **ЦУУТЫН ЦАГААГЧ ГҮҮ**

Дунд сургуулийн сурагчдад зориулав.

Хянан тохиолдуулсан: О.Мөнхтуяа

Хянасан: Ж.Гэрэлмаа

Дизайнер: Т.Дэлгэрмаа

Зураач: Д.Доржнамжим



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК  
2007 он





Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.